

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр
сарын 13-ны өдрийн 09/18/24 дүгээр
албан бичгийн хавсралт

ТӨВ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛ,
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ЦАХИМ САНГ ХӨГЖҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАСИТЕМИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1. Системийн ерөнхий шаардлага

- 1.1. Mozilla Firefox, Google Chrome, Microsoft Edge, Safari зэрэг түгээмэл ашигладаг вэб хөтчүүд дээрсистемийн бүх функц болон загварууд зөвүүгүй ажилладаг байх
- 1.2. Төрийн байгууллагуудын албан хэрэгт мөрдөгдөж байгаа компьютерийн кирилл болон монголүсгийн нэгдсэн кодын ММ8-5552:2005 стандартыг ашигладаг байх
- 1.3. Системийн админ болон хэрэглэгчийн тоог систем нэвтрүүлэлтийн явцад өөрчлөх боломжтой байх
- 1.4. Системийн бүх хэрэглэгчид нэгэн зэрэг ашиглахад систем ачаалал даах чадвартай байх
- 1.5. Төрийн байгууллагуудын албан хэрэгт мөрдөгдөж байгаа нэршил, нэр томъёо ашигласан байх
- 1.6. Системийг хэрэглэхэд хялбар ойлгомжтой байх (user friendly interface)
- 1.7. Системийн аюулгүй байдал, нууцлал хамгаалалтыг бүрэн хангасан байна (SSL гэх мэт)
- 1.8. Мэдээлийн баазыг архивлах, архиваас нөхөж харах боломжтой байх
- 1.9. Бүх хэрэглэгчдэд үндсэн болон дэд системүүдин тайлан, мэдээ нь Dashboard хэлбэрээр шуудхарагддаг байх.

2. Доорх хууль, тогтоомжуудад бүрэн нийцсэн байна.

- 2.1. Монгол Улсын хуулиуд:
 - 2.1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
 - 2.1.2. Төсвийн тухай хууль
 - 2.1.3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайхууль
 - 2.1.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- 2.2. Засгийн газрын тогтооууд:
 - 2.2.1. Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам"
 - 2.2.2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"
- 2.3. Сайдын тушаалууд
 - 2.3.1. Эдийн Засаг хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"
 - 2.3.2. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", "загвар маягт"
- 2.4. Аймгийн Засаг даргын захирамж:
 - 2.4.1. Төв аймгийн Засаг даргын 2022 оны А/300 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"

3. Аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, тайлагнал, хяналт үнэлгээнийцахим сан

№	Системийн нэр
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ	
1.	Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийг өргөн мэдүүлэх, батлах
2.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өргөн мэдүүлэх, батлах
3.	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг өргөн мэдүүлэх, батлах
4.	Аймгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлах
ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГА	
5.	Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг, явцын хяналт-шинжилгээ
НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ-ЦАХИМ АЙМАГ	
6.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, хяналт үнэлгээ, дүгнэлт зөвлөмж
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, хяналт үнэлгээ, дүгнэлт зөвлөмж
8.	Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тайлан, хяналт үнэлгээ, дүгнэлт зөвлөмж
9.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хяналт үнэлгээ, дүгнэлт зөвлөмж

_____оOo_____